

БАТЛАВ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА

Г.ЧИНЗОРИГ

АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

2022 оны 03 дугаар
сарын 01-ны өдөр

№ 13/2219

Улаанбаатар хот

Энэхүү **АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ** (цаашид “Гэрээ” гэнэ)-г нэг талаас Харилцаа Холбооны Зохицуулах Хороо, түүнийг төлөөлж Зах зээл, үнэ тарифын зохицуулалтын газрын дарга **Д.АРИУНБОЛД** (цаашид “**ЗАХИАЛАГЧ**” гэх), нөгөө талаас **АРИСТОН ХХК (РД-5355214)**-ийн захирал **З.ГАНТУЛГА** (цаашид “**АЖИЛ ГҮЙЦЭТГЭГЧ**” гэх) нар Монгол улсын Иргэний хуулийн 343 дугаар зүйл болон холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм, журмыг удирдлага болгон дараах нөхцөлийг харилцан тохиролцож байгуулав.

1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1. Энэхүү гэрээгээр Ажил гүйцэтгэгч нь **энэхүү гэрээний хавсралт ажлын даалгаварт** заасан судалгааны ажлыг хугацаанд нь, чанартай хийж гүйцэтгэж, захиалагч талд хүлээлгэн өгөх, нөгөө талаас Захиалагч нь гэрээнд заасан хугацаанд төлбөрийг төлөхтэй холбогдон талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг хариуцлагатай холбоотой харилцааг зохицуулна.
- 1.2. Энэхүү гэрээнд зохицуулагдаагүй харилцааг Монгол Улсын Иргэний хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.

2. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

- 2.1. Энэхүү гэрээ нь 2022 оны 03 дугаар сарын 01-ны өдрөөс 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийг хүртэл хугацаатай байна.
- 2.2. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас Ажил гүйцэтгэгч нь ажлыг хугацаанд нь гүйцэтгэж чадахгүйд хүрвэл Захиалагчид нэн даруй мэдэгдэж Захиалагч нь нэмэлт хугацаа тогтоож өгнө.

3. АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛБӨР

- 3.1. Гэрээгээр гүйцэтгэх ажлын төлбөр нийт 19 000 000 (Арван есөн сая) төгрөг байх бөгөөд Захиалагч нь холбогдох хуулийн дагуу татвар, шимтгэлийг суутган олгоно.
- 3.2. Гэрээт ажлын эхний үе шатны ажлыг хийж гүйцэтгэн захиалагчид гарган өгсөний дагуу нийт төлбөрийн 50%-ийг явцын тайлан, ажил хүлээлцсэн актыг үндэслэж Ажил гүйцэтгэгчийн /хүлээн авагч: АРИСТОН ХХК / Голомт банкны 1105024643 тоот дансанд шилжүүлнэ.

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА
Г.ЧИНЗОРИГ

- 3.3. Энэхүү гэрээний 3.1-д заасан нийт төлбөрт ажил гүйцэтгэх гэрээний явцад нэмэлт, өөрчлөлт орж болох бөгөөд энэ тохиолдолд талууд тухай бүр акт үйлдэнэ. Акт нь гэрээний салшгүй нэг хэсэг болно.
- 3.4. Зөвлөх үйлчилгээний ажлыг бүрэн гүйцэтгэж дууссаны дараа ажлын тайланг хүлээн авахдаа судалгааны ажил бүрэн хийж гүйцэтгэсэн тухай акт үйлдэж гэрээний 3.2-т заасан дансаар үлдэгдэл төлбөр 50%-ийг шилжүүлэн судалгааны ажлыг Ажил гүйцэтгэсэн АКТ-аар хүлээлцэнэ.

4. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 4.1. Ажил гүйцэтгэгчийг ажлын даалгавар болон шаардлагатай мэдээллээр хангах үүрэгтэй.
- 4.2. Гэрээнд заасан хугацаа болон ажлын үр дүнг хүлээн авмагц ажил үйлчилгээний төлбөрийг төлөх үүрэгтэй.
- 4.3. Гүйцэтгэсэн ажлын үр дүнг гэрээнд заасан хугацаанд хүлээн авах үүрэгтэй.
- 4.4. Захиалагч нь ажлын үр дүнг хүлээн авснаас хойших аливаа эрсдэлийг дангаар хариуцах үүрэгтэй.
- 4.5. Ажил гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн ажил, үүргээ зөрчиж ноцтой алдаа, дутагдал гаргасан болон хугацаа алдсан тохиолдолд Захиалагч нь энэхүү гэрээг нэг талын санаачилгаар цуцлах ба өөрт учирсан хохирлоо нөхөн төлүүлэх эрхтэй.
- 4.6. Захиалагч нь баталгаат хугацааны (1 сар) дотор ажлын үр дүнд доголдол илэрсэн тохиолдолд тухайн доголдлыг арилгуулахаар Ажил гүйцэтгүүлэгчээс шаардах эрхтэй.
- 4.7. Гүйцэтгэсэн ажлын үр дүн доголдолтой бол ажил гүйцэтгэгчийн зардлаар уг доголдлыг арилгуулах, эсхүл ажлыг шинээр гүйцэтгүүлэхээр шаардах эрхтэй.

5. АЖИЛ ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 5.1. Гэрээгээр хүлээсэн ажил, үүргийг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, стандартын дагуу мэргэжлийн өндөр түвшинд хийж гүйцэтгэн гэрээнд заасан хугацаанд нь Захиалагчид хүлээлгэн өгөх үүрэгтэй.
- 5.2. Гүйцэтгэсэн ажлын үр дүнг Захиалагчид хүлээлгэн өгөхөөс өмнө ажлын үр дүнд учирч болох эрсдэлийг дангаар хариуцах үүрэгтэй.
- 5.3. Гэрээгээр хүлээсэн ажил, үүргийг биечлэн гүйцэтгэх үүрэгтэй.
- 5.4. Дараах тохиолдолд Захиалагчид нэн даруй мэдэгдэх үүрэгтэй:
- 5.4.1. Ажил гүйцэтгүүлэхээр Захиалагчийн өгсөн зааварчилгаа, даалгавар нь ажлын чанар, үр дүнд муугаар нөлөөлөхөөр байвал;
- 5.4.2. Ажлын чанар, үр дүнд муугаар нөлөөлөхөөр, ажил гүйцэтгэгчээс үл хамаарах ямар нэгэн нөхцөл байдал бий болсон.
- 5.5. Ажил гүйцэтгэгч нь энэхүү гэрээнд заасан үүргээ биелүүлээгүйгээс Захиалагч болон гуравдагч этгээдэд учирсан аливаа хохирлыг дангаар хариуцан арилгах үүрэгтэй.
- 5.6. Захиалагчид өмчлөлд ямар нэгэн доголдолгүй үр дүн шилжүүлэх үүрэгтэй.
- 5.7. Ажлын үр дүн доголдлыг арилгахад шаардагдах зардлыг хариуцах үүрэгтэй.
- 5.8. Ажил гүйцэтгэгч нь ажил үйлчилгээний төлбөрийг гэрээнд заасны дагуу шаардах эрхтэй.



5.9. Ажил үйлчилгээний даалгаврын талаарх аливаа мэдээллээр хангагдах эрхтэй.

6. ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

6.1. Талууд энэхүү гэрээнд заасан хугацаанд үүргээ гүйцэтгээгүй эсвэл зохих ёсоор гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй ажлын үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцэх алданги төлнө.

6.2. Хэрэв талуудын хооронд маргаан гарвал талууд эвийн журмаар шийдвэрлэхийг эрмэлзэх ба маргаанаа шийдвэрлэж чадахгүйд хүрвэл Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

7. БУСАД

7.1. Талууд энэхүү гэрээнд гарын үсэг зурж захиалагч тал баталснаар хүчин төгөлдөр болно.

7.2. Талууд харилцан тохиролцож Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

7.3. Гэрээний нэмэлт, өөрчлөлт нь зөвхөн бичгээр хийгдэж талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

ЗАХИАЛАГЧ:

ЗЗҮТЗГ-ЫН ДАРГА

Д.АРИУНБОЛД

Гарын үсэг _____

ЗУХАГ-ЫН ДАРГА

З.ЭРДЭНЭЧУЛУУН

Гарын үсэг _____

АЖИЛ ГҮЙЦЭТГЭГЧ:

АРИСТОН ХХК-ийн ЗАХИРАЛ

З.ГАНТУЛГА

Гарын үсэг _____

Хаяг:

Утас: 99055098

ЗЗҮТЗГ-ЫН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Т.ГАНБАТ

Гарын үсэг _____

Метро бизнес төв, А-корпус, 5 давхар

Бага тойруу, 6 дугаар хороо

Сүхбаатарын гудамж-13

Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот,

14201 Утас: 304258
